



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/208

Мандалговь

Хязгаарлалт тогтоож, тэг зогсолт  
хийсэн хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 54 дүгээр тогтоол, Аймгийн Онцгой комиссын 2021 оны 17 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавирус (COVID-19)-ын халдварын тохиолдол нэмэгдэж байгаа нөхцөл байдалтай холбогдуулан тандалт судалгааны ажлыг зохион байгуулах, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор 2021 оны 06 дугаар сарын 13-ний өдрийн 06:00 цагаас 06 дугаар сарын 15-ны өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд Сайнцагаан, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Цагаандэлгэр, Өлзийт сумын хэмжээнд иргэн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарласан хугацааг сунгасугай.
2. Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/207 захирамжид заагдсан заалтуудыг үргэлжлүүлэн мөрдөхөөр зохицуулсугай.
3. Өвчлөлийн тархалтын байдлыг тогтоох, илрүүлэх хүртэлх хугацаанд халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн гэрээсээ гарахгүй байх, иргэний журамт үүргээ ухамсарлаж мэргэжлийн байгууллага, алба хаагчдаас тавьж буй шаардлагыг бүрэн биелүүлж ажиллахыг нийт иргэдэд уриалсугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



481210570